

- чиглэл болох пост-позитивизм, консррактивизмын талаар судалгааг эхлүүлэх;
- ОУХ-ны шинжлэх ухааны судалгаа англи хэл дээр голчлон байх учир монгол хэл рүү нэр томъёонуудыг хөрвүүлэн нэг мөр болгох зайлшгүй шаардлага байна.
- Дээрх саналууд бол Монгол нөхцөл, сууринд тулгуурласан, монголчлох сэтгэхүйгээр ОУХ-г судлах гэж байгаа бус харин "нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн" онолын сургуулиуд Монгол улсад хэрхэн нөлөөлөх гэдэгт чиглэж байгаа юм. Нөгөө талаар, ОУХ-ны онолын судалгааны ажиг монголын судлагчдад өргөн цар хүрээтэй, дэлхийн түвшинд судалгаа явуулах суваг нээж байгаа юм.

#### НОМЗҮЙ:

1. Booth, K. & Smith, S. (eds) 1995 : *International Relations Theory, The Pennsylvania State University Press*, 1995
2. Kegley Jr., C. W. & Wittkopf, E. R. 1993: *World Politics, Trend and Transformation*, 4<sup>th</sup> ed., NY: St. Martin's Press.
3. Viotti, P. R. & Kauppi, M. V. - 2<sup>nd</sup> ed., 1993: *International Relations Theory: Realism, Pluralism, Globalism*, NY: Macmillan Publishing Company
4. Cox, Robert W. & Timothy J. Sinclair 1996: *Approaches to World Order*, Cambridge, p.82.
5. Lopez, G. A. & Stohl, M.S. 1989: *International Relations: Contemporary Theory and Practice*, Congressional Quarterly.
6. Төмөрчулуун, Г. 1995 (а) "Прагматизм: 90-ээд оны Монголын гадаад бодлогын үндэс" (Батбаяр, Ц. (ред.), 1995: 1990-ээд оны Олон Улсын Харилцааны Хандлагууд: Монгол Улс – Их гурнуудийн харилцаа, УБ.
7. Бор, Ж. 2000: Олон Улсын Бодлогозүйн Онолын Асуудалд. Алтан Арсаж, 1, (3) 3-8.
8. Төмөрчулуун, Г. 1995 (б). ОУХ-ны Онолын Сургуулиуд. Шинэ Толь. 1/1995. 59-63.

## ДЭН СЯОПИНЫ ҮЕИЙН БНХАУ-ЫН ГАДААД БОДЛОГО

МУИС, ОУХС-ийн 3-р ангийн  
оюутан Я.Болд-Эрдэнэ

БНХАУ-н II үеийн удирдагч гэж алдаршсан Дэн Сяопин (1904-1997) нь Хятадын удирдагчдаас хамгийн өндөр насалсан, хамгийн олон албан тушаалыг хавсран гүйцэтгэж байсан хүн юм. Тэрээр 1980-д оныг хүртэл нэг бус удаа ерөнхий сайдын орлогчийн албыг хашиж байсан, Орос, Францад боловсрол эзэмшсэн. Хэнтэй ч юуны ч талаар сонирхолтой яриа өрнүүлчихдэг, гадныхны өмнө биеэ авч явах өндөр соёлтой нэгэн байжээ. Тэр өөрийгөө тахин шүтүүлээгүйгээрээ онцлогтой.

Мао Эздүны дараа Хятадын төрийн эрхийг Хуа Гофэн хэдэн жил барьсан билээ. Хуа Гофэний үед БНХАУ-н гадаад бодлого Хятадын өнөөгийн гадаад бодлогын дүр төрхийг олж эхэллээ. Гэхдээ түүнд гол гавьяатан нь 1977 оноос засгийн эрхэнд дахин гарч ирсэн Дэн Сяопин байсан юм.

1978 онд ЖНН-н 11 дэх удаагийн 3 дахь бүгд хуралдаанаар Дэн Хятадын онцлогтой социализм байгуулах "Нээлттэй хаалганы бодлого", "4 шинэчлэлийн бодлого" дэвшүүлсэн ба дотоод гадаадын нөхцөл байдлаас хамаарч гадаад бодлогод ч зарим нэг өөрчлөлт гарсан.

Дэн "Социалист Хятад нь 3 дахь ертөнцөд хамаарах ба тэдний талд байх болно" хэмээн цохон тэмдэглээд Хятадын гадаад бодлогын үндэс нь хөгжиж буй орнуудтай хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх Ази, Африк, Латин америкийн орнуудтай харилцан ашигтай, найрсаг, хамтын ажиллагааг баталгаажуулахад оршино" гэж үзэж байжээ. Тэрээр улс хоорондын харилцааг голлосон нийгмийн байгуулал, үзэл суртлын хооронд ямар нэг тэмцэл байх учиргүй хэмээн "ЗХУ, АНУ-тай харилцах чиг шугамаа өөрчлөн дэлхийн бүх оронтой найрсаг хамтын ажиллагааг өргөтгөхийг зорьжээ.

Ийнхүү 1979 оноос БНХАУ шинэчлэлийн замд орсныг Хятадын түүхэн дэх 3 дахь үсрэлт гэдэг. (Эхний нь 1911 онд Манжийн дарлалыг унагасан, удаах нь 1949 онд БНХАУ-г байгуулсан явдал болно.) "Шинэчлэл, нээлттэй бодлого" нь гадаадын шинэ түнш эрж хайж хамтран ажиллахыг шаардсан. 1980 онд тэнгисийн эргийн дагуу 4

онцгой бус нээж 1984 онд дахин 14 болгов. Дэн прагматизмын онолыг баримтлан "Муур цагаан байна уу хар байна уу хамаагүй, галцхуу хулгана барьж идэх хэрэгтэй" гэсэн. Энэ нь "Хятад улсад ямар нийгмийн байгуулал тогтох нь хамаагүй галцхуу Хятад улс хөгжих учиртай" гэсэн үг аж.

1982 онд Хятадын Коммунист Намын 12-р Их БНХАУ-ын шинэ Үндсэн хуулийг баталсан. Үндсэн хуулийн оршлын хэсэгт тус улсын гадаад бодлого, гадаад харилцаанд баримтлах үндсэн чиг шугам, зарчмуудын тухай заахдаа "Хятад улс нь бие даасан хараат биш бодлого явуулж бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийнхээ бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, харилцан үл довтлох, тэгш эрх, харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмуудыг баримталж, бусад улс оронтой дипломат болон эдийн засаг, соёлын харилцааг хөгжүүлнэ. Хятад улс нь империализм, жанжлал, колонизмийг эсэргүүцэх, бөгөөд дэлхийн улс түмэнтэй эв нэгдлээ бэхжүүлэх байр суурийг тууштай баримтлан дарлагдсан үндэстэн, ба хөгжиж байгаа орнуудын эдийн засгаа хөгжүүлэхээр хийж байгаа шударга тэмцлийг дэмжиж дэлхийн энх тайвныг хамгаалах, болон хүн төрөлхтний дэвшилтэт үйлсэд тус дөхөм үзүүлэхийн төлөө хүчин чармайлт тавих болно" гэсэн байдаг. Ийнхүү энэ хурлаас "БНХАУ-н бие даасан энх тайванч" гадаад бодлогыг анх дэвшүүлсэн. Энэхүү бодлогод зааснаар их гүрнүүдтэй харилцах харилцаа нь тэргүүлэх чиглэл хэмээжээ.

Дэн Сяопины гадаад бодлогын бас 1 хэсэг нь Хонг Конг Макаогийн асуудлыг "1 улс 2 систем" номлолоороо шийдэж 1982 онд Их Британитай, 1986 онд Португалитай хэлэлцээ амжилттай хийн эх оронд нь нэгтгэхээр тохиролцсон явдал бөгөөд энэ нь бусад улсад энх тайвнаар нэгдэх үлгэр жишээ болж өгсөн.

Ингээд тухайн үеийн БНХАУ-н дэлхийн бусад орнуудтай хэрхэн харилцаж байсан талаар товчхон авч үзье.

#### ЗХУ, социалист орнуудтай харилцах харилцаа

80-д онд Хятадын Гадаад бодлогод ЗХУ хамгийн аюултай дайсан нь байсан (ЗХУ-г социал империализм гэдэг байв). Иймээс ч АНУ-тай харилцаагаа сайжруулахыг зорьж байсан. 1982 онд "Энх тайванч, бие даасан гадаад бодлого" дэвшүүлснээр ЗХУ-тай харилцаа нь сайжрах төлөвтэй болсон.

Брежневийн үед Оросын талаас Хятадтай харилцаагаа хэвийн болгохыг оролдоогүй. 2 орны хооронд ГЯЯ орлогч сайд нарын хэмжээнд улс төрийн зөвлөлдөөн явуулж, үр дүнтэй хэдэн жил маргаснаас бус асуудлын голыг ольё" гэсэн чармайлт бага байлаа. Хятадын талаас Зөвлөлттэй харилцаа сайжруулах зорилгоор 3 харш саадыг арилгах санал дурьдсан.

1. Монголоо цэргээ гаргах
2. Афганистанаас цэргээ гаргах
3. Камбожид ноцтой байдал бий болгосон Вьетнамад шахалт үзүүлэх

Горбачёв эхэндээ няцааж түүнийг нь сөргүүлэн үзэл суртлын зорилгоор энх тайванч санал дэвшүүлж байв. Гэтэл 1985-6-4 нд Зөвсэгт хүчний ерөнхий командлагч Дэн Сяопин Хятадын засгийн газар 2 жилийн дотор цэргээ 1 саяар цөөлөх тухай тогтоолыг гаргасан нь илүү үр дүнтэй болжээ. 1988 он Горбачёв НҮБ-н Ерөнхий Ассамблейн Чуулган дээр санал дэвшүүлсэн нь дэлхий нийтийн анхаарлыг татсан. Хятадтай харилцах харилцаанд нааштай хандлага ажиглагдлаа. Зөвлөлт Хятадын харилцаа сайжрахад Хятадтай нэгэнт сайн харилцаатай соц орнууд (БНАГУ, Румын) багагүй зуучилж байжээ.

БНХАУ ЗХУ-н мажлийн социализмд орохгүй байхаар эргэлт буцалтгүй шийджээ. Цөмийн зэвсэг бүтээж, НҮБ-д хууль ёсны байр сууриа эзлэн, Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн болж өөрийгөө АНУ, Өрнөд Европ, Японоор хүлээн зөвшөөрүүлэх гүрэн болгох замаа тавьсан учраас Хятадын хувьд социалист систем шийдвэрлэх гол асуудал биш байв. Иймч учраас 80-д онд Соц системийн хувьд явуулсан бодлого нь 2 онцлогтой:

1. Системийн дотор эв нэгдлийг сулруулах. ЗХУ-н давамгайл байдлыг алдагдуулах. Үүнийгээ бүх улс тэгш эрх байх ёстой хэмээх тайлбарлаж байв.

2. Соц орнуудад өгөх тодорхойлолтоо өөрчилсөн. Энэ тодорхойлолтдоо Дорнод европыг нэмж оруулсан. Гэхдээ Дорнод Европд ардын дипломат бодлого идэвхитэй явуулахын сацуу тэдгээр орноор Хятадыг дэмжүүлэх гэж мэрийх болсон.

#### АНУ болон өрнөдийн орнуудтай харилцах харилцаа

АНУ-тай харилцаагаа сайжруулах нь цаагуураа Тайванийн

асуудлыг нааштайгаар шийдэх далад зорилготой байсан. 1978 онд 2 тал уулзан хамтарсан мэдэгдэл гаргаж 1979-1-1 онд АНУ (Ерөхийлөгч Ж. Картер) - БНХАУ 2 дипломат харилцаа тогтоосноор АНУ 4 сарын дотор Тайванаас цэргээ гаргахаар тогтсон нь гол ололт байлаа. Үүнийг залгаад БНХАУ-ын ТЭ-н ерөнхий сайдын орлогч Дэн Сяопин АНУ-н айлчлав. Тэр цагаан ордонд хэлсэн үгэндээ "Манай 2 орны харилцаанд шинэ үе эхэллээ. Хятадлын удирдагч анх удаа Америкт айлчилж байна. Энэ айлчлал нь харилцан ойлголцлыг бэхжүүлэх Ази Номхон далайн бүс нутагт энх тайвныг тогтооход их нөлөөтэй нь эргэлзээгүй юм" гэжээ.

1981 оны сүүлээр 2 улс зэвсэглэлийн асуудлаар хэлэлцэж 10 сарын дараа тохиролцоонд хүрч 1982-8-17нд "8 сарын 17-ны хамтарсан мэдэгдэл"-г гаргажээ.

Хятад Японы харилцаа ч сайжирлаа. 1978-8-12нд энх тайван найрамдлын гэрээ байгуулснаар харилцаа шинэ шатанд гарсан бөгөөд энэ нь Ази Номхон далайн бүс нутагт тогтвортой байдлыг хангах чухал хүчин зүйл болов

Их Британиитай Хонг Конгийн асуудлаар хэлэлцээ амжилттай хийсэн Франц, Итали, Герман, Англи зэрэг ерөндийн орнуудын эрх баригчидтай харилцан айлчлал хийжээ.

### 3 дахь ертөнцтэй харилцсан нь

1982 оноос Хятад, Хөгжиж буй орнуудтай эдийн засаг, техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх 4 зарчим дэвшүүлж, түүнийгээ Өмнө, Зүүн өмнөд Ази Номхон далайн орнууд, Латин Америкийн орнуудын хамтын ажиллагааны мөрийн хөтөлбөр болгохыг зорьсон. Энэ нь:

1. Хятадын гадаад бодлого реформыг хэрэгжүүлэхэд эдгээр орнуудын хүчийг ашиглах, үүний тулд хүүгүй зээл олгох, бэлгийн журмаар зэвсэг нийлүүлэхээ зогсоож оронд нь хямдхан ажиллах хүч экспортлох, хямд төсөр барилга барьж өгөх
2. Дотор нь ялгавартай хандах бодлого явуулах, социалист чиг баримжаагаар хөгжих Зөвлөлтийн номлол хэрэгжихгүй байгааг харгалзан нөлөөг нь сулруулах
3. Хятадад элэгтэй орнуудын зэвсэг маягийн юм бий болгох. Энд Пакистан, Чили, Судан, Заир, Ираныг ихээхэн анхаарч, Энэ бодлогодоо "Хүйтэн дайн"-ыг овжин ашиглах

4. Латин америкийн 14 улс Африк, Арабын зарим томоохон орон Тайвантай албан ёсны харилцаатай байгааг бусчилж олон улсын тавцанд Тайванийг ганцаардуулах.

Нэгтгэн дүгнэвэл БНХАУ 3 дахь ертөнцөд ЗХУ, АНУ-н байр суурийг сулруулах, орон зайг нь эзлэх бодлого явуулж байжээ. 1979-89 Хятад 3 дахь ертөнцтэй харилцаагаа өргөжүүлж Португалитай хэлэлцээ амжилттай хийсэн.

1987-10-25 ХКН XIII их хурлаар Дэн БНХАУ-ын даргын 1989-10 сард ХКН XII их хурлын 5-р хуралдаанаар зэвсэгт хүчний командлагчийн албан тушаалаас буссан байна.

1992 оны 1-18-21 Дэн Сяопин Учан, Шэнжэн, Жухай, Шанхай зэрэг газраар явж 1978 оноос хойшхи их ажлын үр дүнгээс яасан ч гуйвалзаж болохгүй зорилготой бай "Хөгжил бол хатуу ёс" хэмээн ард түмнээ дахин нэг ухуулжээ. Дэн Сяопин Хонг Конгийг эх орондоо нэгтгэх үйл явцыг үзнэ гэж ихэд найдаж байсан ч үүнээс тавхан сарын өмнө буюу 1997-2 сард 92 насандаа ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн юм.

Эцэст нь дүгнэхэд Дэн Сяопиний үед Хятад гадаад бодлогодоо ихээхэн амжилт олжээ. Үүнд:

- Өөрийн бүрэн эрхт байдал, үндэсний байр сууриа амжилттай хадгалсаар ирсэн;
- Хонг Конг Макаог эх орондоо нэгтгэсэн нь энх тайвнаар нэгдэх томоохон жишээ болсон;
- Сайн хөршийн харилцааг өргөтгөн хөрш орнуудтайгаа найрамдал хамтын ажиллагааг өргөтгөсөн;
- Ихэнхи хөгжиж буй орнуудтай хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг батжуулсан;
- Энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмын үндсэн дээр Зүүн Европын улсууд, ТУХН-н орнуудтай харилцаагаа өргөжүүлж Барууны орнуудтай харилцаагаа сайжруулсан;
- Шинэчлэл нээлттэй бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх олон улсын тааттай нөхцөл байдал бий болгосон;
- Бүс нутгийн болон олон улсын харилцаанд чухал байр сууритай болсон;
- БНХАУ ОУ нилгээд олон байгууллагад элсэн орсон. Энд : ОУВС, Дэлхийн банк, НҮБ-ийн худалдаа хөгжлийн конференц, UNICEF, НҮБ-н Соёл ШУ-ны байгууллага, Дэлхий эрүүл мэндийн байгууллага, МҮА зэрэг болно.